



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 62


Мандалговь

Автомашинд үнэлгээ тогтоож,
худалдах тухай

Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дугаар зүйлийн 3 дахь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 6.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Тувааны нэрэмжит Нэгдсэн эмнэлэгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2009 онд ашиглалтанд орсон 40,954,500 / дөчин сая есөн зуун тавин дөрвөн мянга таван зуун/ төгрөгийн өртөгтэй элэгдээрээ анхны өртгөө нөхсөн 49-97 ДУА улсын дугаартай Донг Пенг маркын автомашины худалдах доод үнийг 1,500,000 /нэг сая таван зуун мянган/ төгрөгөөр тогтоон худалдахыг зөвшөөрсүгэй.
2. Эд хөрөнгийг хууль журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.
3. Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Тувааны нэрэмжит Нэгдсэн эмнэлэгийн дарга /Х.Жаргал/-д даалгасугай.
4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХТ-ийн 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 25 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.
5. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга С.Ууганбаярт үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

0100144